



МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Түр журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.1, 6.1.4, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрчим хүчний сайдын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар батлагдсан "Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах түр журам"-ын 4.8 дахь хэсгийг дараах байдлаар өөрчилсүгэй.

"4.8.Шинээр холбогдсон, халаалтаа цахилгаанаар бүрэн шийдсэн, ижил төстэй хэрэглэгчийн өмнөх оны мөн үеийн дунджаас бага хэрэглээтэй байсан, гэрээний эзэмшигч өөрчлөгдсөн хэрэглэгчийн төрөөс хариуцах төлбөрийн хэмжээг тухайн хэрэглэгчийн хэрэглээний гүйцэтгэлийг харгалзан ижил төстэй айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын дундаж хэрэглээтэй дүйцүүлж тогтооно."

2.Журамд орсон өөрчлөлтийг мөрдөж ажиллахыг эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэр, компаниудын гүйцэтгэх захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Насантогтох/-д даалгасугай.

Н.ТАВИНБЭХ

170600010



МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 269

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 70.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас айл өрх, зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөрийг төрөөс хариуцах болсонтой холбогдуулан “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэр, компаниудын захирал, дарга нарт даалгасугай.

3. Энэхүү журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /Р.Батрагчаа/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Насантогтох/-д даалгасугай.



Н.ТАВИНБЭХ

170600653



## **ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ, ДУЛААНЫ УУРЫН ТӨЛБӨР ТООЦООГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур, цэвэр, бохир усны төлбөр болон хог хаягдлын үйлчилгээний хураамжийн зарим хэсгийг төрөөс хариуцах тухай" 211 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор айл өрхийн болон зарим үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр /цаашид "эрчим хүчний төлбөр" гэх/-ийг төрөөс хариуцахтай холбоотой төлбөр тооцооны үйл ажиллагааг энэхүү түр журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын зохицуулалтад Эрчим хүчний зохицуулах хороо болон аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлөөс олгосон цахилгаан, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид, тэдгээртэй гэрээ байгуулсан хэрэглэгчдэд хамаарна.

1.3. Эрчим хүчний зохицуулах хороо болон аймаг нийслэлийн зохицуулах зөвлөл энэхүү журам хэрэгжих хугацаанд хэрэглэгчийн тарифт өөрчлөлт оруулахгүй.

### **Хоёр. Хамрах хүрээ**

2.1. Айл өрхийн болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 1-д заасан хэрэглэгчдээс бусад аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний төлбөр энэхүү журам хамаарна.

Айл өрхийн эрчим хүчний хэрэглээний дараах төлбөр нь энэхүү журамд хамаарахгүй. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор баталсан "Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам", 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн "Журамд өөрчлөлт оруулах тухай" 115 дугаар тогтоолын хүрээнд тарифт тоолууртай айл өрхийн халаалтын улирлын орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны хөнгөлсөн төлбөр;

2.2. Аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний хэрэглээний дараах төлбөр нь энэхүү журамд хамаарахгүй. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолын 1-д заасан хэрэглэгчдийн төлбөр;
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 324 дүгээр тогтоолд заасан өвлийн хүлэмжийн аж ахуйн цахилгааны хэрэглээний төлбөр.

## **Гурав. Үйлчлэх хугацаа**

3.1. Энэхүү түр журмыг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд мөрдөнө.

### **Дөрөв. Төрөөс хариуцах эрчим хүчний төлбөрийг тодорхойлох**

4.1. Цахилгаан, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл авсан эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчид /цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигчид гэх/ төрөөс хариуцах айл өрх, зарим аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэсэн эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хороо болон аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлөөс баталсан хэрэглэгчийн тарифын ангилал тус бүрээр тооцно.

4.2. Эрчим хүчний эх үүсвэр болон шугам сүлжээний техникийн хүчин чадлын боломжит хэмжээтэй уялдуулан хэрэглэгчийн эрчим хүчний төрөөс хариуцах төлбөрийн хэмжээг өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй ижил хэмжээгээр тооцно. Орон сууцны айл өрхийн хувьд 100 метр квадратаас доош талбайд ногдох дулааны төлбөрийг төрөөс хариуцна.

4.3. Шинээр холбогдсон хэрэглэгчийн эрчим хүчний төрөөс хариуцах төлбөрийн хэмжээг тооцохдоо тухайн хэрэглэгчийн хэрэглээний гүйцэтгэлийг харгалзан ижил төстэй айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын дундаж хэрэглээтэй дүйцүүлж тооцно.

4.4. Энэхүү журмын 4.2, 4.3-т заасан хэмжээнээс илүү хэрэглэсэн эрчим хүчний төлбөрийг одоогийн мөрдөгдөж буй тарифаар тооцож хэрэглэгч өөрөө төлнө.

4.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь айл өрх, зарим аж ахуйн нэгж байгууллагын 2019 оны 12 дугаар сар болон 2020 оны 1-6 дугаар саруудын эрчим хүчний хэрэглээний гүйцэтгэлийг биетээр болон мөнгөн дүнгээр гарган баталгаажуулж, 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор Эрчим хүчний зохицуулах хороонд бичгээр болон цахимаар ирүүлнэ.

4.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь төрөөс хариуцах айл өрх, зарим аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэсэн эрчим хүчний тухайн сарын урьдчилгаа төлбөрийг өмнөх оны мөн үеийн хэрэглээний 50 хүртэл хувьтай тэнцэх хэмжээгээр тооцож, өмнөх сарын 28-ны дотор Эрчим хүчний зохицуулах хороонд бичгээр болон цахимаар ирүүлнэ.

4.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь айл өрх, зарим аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэсэн эрчим хүчний 2020 оны 12 дугаар сарын урьдчилгаа төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр тооцон 2020 оны 12 дугаар сарын 18-ны дотор Эрчим хүчний зохицуулах хороонд бичгээр болон цахимаар ирүүлнэ.

4.8. Цахилгаан, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид айл өрх, зарим аж ахуйн нэгж, байгууллагын тухайн сарын эрчим хүчний хэрэглээг өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй харьцуулсан байдлаар хавсралт маягт 1, 1.1, 1.2, 2, 2.1, 2.2-ын дагуу гарган, төрөөс хариуцах төлбөрт хамрагдах дүнг тооцоолж дараа сарын 10-ны дотор Эрчим хүчний зохицуулах хороонд бичгээр болон цахимаар ирүүлнэ.

4.9. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл авсан эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчид айл өрх, зарим аж ахуйн нэгж байгууллагын тухайн сарын эрчим хүчний хэрэглээг өмнөх оны мөн үеийн

хэрэглээтэй харьцуулсан байдлаар хавсралт маягт 1, 1.1, 1.2, 2, 2.1, 2.2-ын дагуу гарган, төрөөс хариуцах төлбөрт хамрагдах дүнг тооцоолж аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлөөр хянуулан дараа сарын 10-ны дотор Эрчим хүчний зохицуулах хороонд бичгээр болон цахимаар ирүүлнэ.

4.10. Заасан хугацаанд багтааж төлбөрийн тооцоог Эрчим хүчний зохицуулах хороонд ирүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тооцоог дараа сар хүртэл хойшлуулна.

4.11. Тухайн хэрэглэгчийг эрчим хүчээр хангаж буй байгууллага нь тусгай зөвшөөрөлгүй тохиолдолд уг хэрэглэгчийг тухайн хангагчид эрчим хүч нийлүүлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын хэрэглэгч гэж үзнэ.

#### **Тав. Эрчим хүчний төлбөр тооцоог хянан баталгаажуулах**

5.1. Эрчим хүчний зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн нэхэмжлэхийг ажлын 3 хоног хүртэл, гүйцэтгэлийг ажлын 5 хоног хүртэл хугацаанд багтаан хянаж Эрчим хүчний яаманд хүргүүлнэ.

5.2. Эрчим хүчний яам нь Эрчим хүчний зохицуулах хорооноос хянасан урьдчилгаа төлбөр болон гүйцэтгэлийг ажлын 2 хоног хүртэл хугацаанд багтаан хянан баталгаажуулж, санхүүжилтийн хүсэлтийг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлнэ.

#### **Зургаа. Эрчим хүчний төлбөр тооцоог хийх**

6.1. "Диспетчерийн үндэсний төв" ХХК нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд эрчим хүчний төлбөр хийх эрх бүхий байгууллага байна.

6.2. "Диспетчерийн үндэсний төв" ХХК нь "Нэг худалдан авагчтай загвар"-тай гэрээтэй арилжааны банканд Эрчим хүчний яамнаас эрчим хүчний төлбөрийг хүлээн авах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд уг төлбөрийг хийх зориулалт бүхий түр данс нээнэ.

6.3. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь эрчим хүчний төлбөрийг барагдуулах зорилгоор Сангийн яамнаас тусгайлан нээсэн дансанд тухайн сарын санхүүжилтэд шаардлагатай эх үүсвэрийг байршуулна.

6.4. Эрчим хүчний яамнаас ирүүлсэн 2020 оны 12 дугаар сарын урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн хүсэлтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Сангийн яамны Төрийн сангийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хянан үзэж шаардлагатай санхүүжилтийг 2020 оны 12 дугаар сарын 23-ны дотор Эрчим хүчний яамны дансанд шилжүүлнэ.

6.5. Эрчим хүчний яамнаас ирүүлсэн тухайн сарын урьдчилгаа төлбөр болон гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Сангийн яамны Төрийн сангийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хянан үзэж шаардлагатай санхүүжилтийг ажлын 4 хоногийн дотор Эрчим хүчний яамны дансанд шилжүүлнэ.

6.6. Энэхүү журмын 6.3, 6.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон бусад шаардсан баримтыг холбогдох байгууллага яаралтай гаргаж өгнө.

6.7. Эрчим хүчний яам нь Сангийн яамнаас хийгдсэн санхүүжилтийн дүнгээр "Диспетчерийн үндэсний төв" ХХК-ийн түр дансанд ажлын 2 хоног хүртэл хугацаанд багтаан шилжүүлнэ.

6.8. “Диспетчерийн үндэсний төв” ХХК нь Эрчим хүчний яамнаас хянан баталгаажуулсан дүнгээр ажлын 2 хоногт багтаан дараах байдлаар шилжүүлнэ. Үүнд:

- “Нэг худалдан авагчтай загвар”-т хамрагддаг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд орлого төвлөрүүлэлтийн дансанд;
- Эрчим хүчний зохицуулах хороо болон аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл авсан эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд тухайн компанийн нэхэмжлэх дээрх дансанд.

6.9. Сангийн яамнаас Эрчим хүчний яаманд шилжүүлсэн төлбөр нь нэхэмжилсэн дүнгээс бага тохиолдолд Эрчим хүчний яамнаас хянан баталгаажуулсан дүнд үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад хувь тэнцүүлсэн байдлаар төлбөр тооцоог хийнэ.

6.10. “Диспетчерийн үндэсний төв” ХХК нь эрчим хүчний төлбөрийг шилжүүлсэн тухай тайлан, мэдээг Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороонд дараа сарын 5-ны өдрийн дотор хүргүүлнэ.

### **Долоо. Хариуцлага**

7.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Эрчим хүчний зохицуулах хороо нь гаргасан, хянасан төлбөр тооцооны үнэн зөвийг бүрэн хариуцна.

7.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү журамд заасан хугацаанд багтаж төлбөр тооцоог Эрчим хүчний зохицуулах хороонд ирүүлээгүйн улмаас гарах хохирлыг бүрэн хариуцна.

7.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид цахилгаан, дулааны эрчим хүчний төрөөс хариуцах төлбөрийг үндэслэлгүй буруу тооцсон, мэдээллийг хуурамчаар гаргасан, үнэн зөв тооцоо хийгээгүй тохиолдолд төрийн өмчит тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн гүйцэтгэх захирлын гэрээг цуцлах, орон нутгийн өмчит тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн гүйцэтгэх захирлын гэрээг цуцлах саналыг холбогдох газарт хүргүүлэх, хувийн өмчит тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэл арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн авч хэрэгжүүлнэ.

7.4. Дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн дулааны эрчим хүчээр хангаагүй болох нь тогтоогдсон тохиолдолд дутуу нийлүүлсэн дулаанд харгалзах төлбөрийг хасаж тооцно.

--- оОо ---

.....-ын 20... оны ... дугаар сарын хэрэглэгчийн цахилгааны төрөөс хариуцах төлбөрийн тооцоо

**Төлбөр хүлээж авах**

|                      |  |
|----------------------|--|
| Аж ахуйн нэгжийн нэр |  |
| Регистерийн дугаар   |  |

|            |               |
|------------|---------------|
| Банкны нэр | Дансны дугаар |
|            |               |
|            |               |
|            |               |

мян.төг

|                                                                   |                                                                                                                         |  |
|-------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
| 1. Цахилгааны төрөөс хариуцах төлбөрийн дүн - НӨАТ орсон          |                                                                                                                         |  |
| Үүнд:                                                             | ҮААНБ                                                                                                                   |  |
|                                                                   | Ахуйн хэрэглэгч                                                                                                         |  |
| 2. Цахилгааны хэрэглэгч өөрөө хариуцах төлбөрийн дүн - НӨАТ орсон |                                                                                                                         |  |
| Үүнд:                                                             | ҮААНБ                                                                                                                   |  |
|                                                                   | 1/ төсөвт байгууллага                                                                                                   |  |
|                                                                   | 2/ төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд                                                    |  |
|                                                                   | 3/ уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр                                                                           |  |
|                                                                   | 4/ банк, банк бус санхүүгийн байгууллага                                                                                |  |
|                                                                   | 5/ криптовалюттай холбогдох үйл ажиллагаа эрхлэгч                                                                       |  |
|                                                                   | 6/ газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч |  |
|                                                                   | 7/ интернет, үүрэн холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч                                              |  |
|                                                                   | 8/ согтууруулах ундаа, тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч                                                       |  |
|                                                                   | 9/ өнгөт металл болон хар төмөрлөг, цементийн үйлдвэр                                                                   |  |
|                                                                   | Ахуйн хэрэглэгч                                                                                                         |  |

Тооцоолол гаргасан

Захирал

/...../

Нягтлан бодогч

/...../

...ийн 20... оны ... дугаар сарын үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын цахилгааны хэрэглээний гүйцэтгэл

| №    | Үзүүлэлтүүд                                  | Хэмжих нэгж | Цахилгааны нийт хэрэглээ, төлбөр | Төрөөс хариуцах цахилгааны хэрэглээ, төлбөр | Төрөөс хариуцахгүй цахилгааны хэрэглээ, төлбөр |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|------|----------------------------------------------|-------------|----------------------------------|---------------------------------------------|------------------------------------------------|---------------------------------------------------------------|-----------------------------------------------|------------------------------------------|----------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|----------------------------------------------|-------------------------------------------------------|------------------------------------------------------|
|      |                                              |             |                                  |                                             | 1/ Төсөвт байгууллага                          | 2/ Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд | 3/ Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр | 4/ Банк, банк бус санхүүгийн байгууллага | 5/ Кripto валюттай холбогдох үйл ажиллагаа эрхлэгч | 6/ Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч ТЗЗ | 7/ Интернет, үүрэн холбооны үйл ажиллагаа эрхлэх ТЗЗ | 8/ Сogтyууpуулах ундаа, тaмхи үйлдвэрлэх ТЗЗ | 9/ Өнгөт металл болон хар төмөрлөг, цементийн үйлдвэр | 10/ Өвлийн хүлэмжийн аж ахуйн хөнгөлөлтөд хамрагдсан |
| 1    | Хэрэглэгч тоо                                | тоо         |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2    | ҮААНБ-д Борлуулах цахилгаан                  | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2.1  | ҮААНБ-ын чадлын дүн                          | кВт/сар     |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2.2  | Бусад ААНБ / 1 тариф /                       | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Бусад ААНБ /1 тариф/ - чадал                 | кВт/сар     |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Бусад ААНБ / 3 тариф /                       | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Өдрийн /06.00-17.00/                         | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Оройн /17.00-22.00/                          | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2.3  | Шөнийн /22.00-06.00/                         | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | ААНБ /17.00-22.00/ - чадал                   | кВт/сар     |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Төмөр зам                                    | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Цахилгаан тээвэр                             | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Цахилгаан тээвэр - чадал                     | кВт/сар     |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2.4  | СӨХ / 2 тарифт /                             | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2.5  | Өдрийн /06.00-19.00/                         | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Шөнийн /19.00-06.00/                         | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | СӨХ /06.00-19.00/ - чадал                    | кВт/сар     |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Цэнэглэгч станц / 1 тариф /                  | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Цэнэглэгч станц /1 тариф/ - чадал            | кВт/сар     |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2.6  | Цэнэглэгч станц / 3 тариф /                  | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Өдрийн /06.00-17.00/                         | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Оройн /17.00-22.00/                          | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | Шөнийн /22.00-06.00/                         | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
|      | ААНБ /17.00-22.00/ - чадал                   | кВт/сар     |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2.7  | Импорт /Дорноговь, Ханги боомт/ - Уул уурхай | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2.8  | Импорт /Дорноговь, Ханги боомт/ - Бусад ААНБ | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2.9  | Импорт /Хөвсгөл, Ханх/ - Уул уурхай          | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 2.10 | Импорт /Хөвсгөл, Ханх/ - Бусад ААНБ          | мян.кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 3    | ҮААНБ-д борлуулах цахилгааны тариф           |             |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
| 3.1  | ААНБ / 1 тариф /                             | төг/кВт.ц   |                                  |                                             |                                                |                                                               |                                               |                                          |                                                    |                                                                                                    |                                                      |                                              |                                                       |                                                      |
